
АЖЛЫН
ТАЙЛАН
1.5
ЖИЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
ПҮРЭВБААТАРЫН
МӨНХТУЛГА

Эрхэм таны алгаланг айлтган Мэндчилье



Угуул нутгийн минь ахан дүүс, ард иргэд, эрхэм сонгогчид Та бүхэндээ дэлгэр сайхан өдрийн мэнд дэвшүүлье.

Та бүхний итгэлийг хүлээн Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж буй энэ хугацаандаа мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж, орон нутгийнхаа хөгжилд бодит хувь нэмэр оруулахын төлөө хичээн ажиллах хариуцлагатай үе тохиож байна.

Миний хувьд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн байнгын хороо, Өргөдлийн байнгын хороо болон холбогдох ажлын хэсгүүдэд ажиллах хугацаандаа улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаадын тусламж, санхүүжилтийн хүрээнд тойрогтоо шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийг тусгуулахын төлөө хичээнгүйлэн ажилна.

УИХ-ын гишүүний хувьд тойргийнхоо иргэд, сонгогчидтой тогтмол холбоотой ажиллаж, хэрэгцээ шаардлагад нь тулгуурласан бодит ажлуудыг хэрэгжүүлэхийг зорьж байна. Энэхүү ажлын тайлан товхимол нь өнгөрсөн хугацаанд хийсэн ажил, нутгийн хөгжилд чиглэсэн бүтээн байгуулалтууд, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн төслүүдийн талаарх товч мэдээллийг танд хүргэж байна.

Цаашид ч би УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хугацаандаа ард иргэдэд ээлтэй хууль, бодлогын шинэчлэлүүдийг санаачлан батлуулах, батлагдсан хуулийн хэрэгжилтийг бодит үр дүнд хүргэх, мөн Хангайн бүсийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэхийг нэн тэргүүнд тавин ажиллах болно.

Нутгийн зон олондоо ажил үйлс нь өдөө, амьдрал нь аз жаргал, баяр баяслаар дүүрэн, эрүүл энх, саруул сайхан байхыг хүсэн ерөөе.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
АРХАНГАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА



ПҮРЭВБААТАРЫН МӨНХТУЛГА

УИХ-ЫН ГИШҮҮНИЙ ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛ

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хуралд сонгогдсон гишүүд тангаргаа өргөж, ард түмний өмнө хүлээсэн үүргээ албан ёсоор эхлүүлдэг уламжлалтай. Энэ нь парламентын шинэ бүрэлдэхүүний үйл ажиллагаа эхлэхийг зарлан тунхагладаг, улс төрийн соёл, төрийн дархлааг илтгэх онцгой ёслолын нэг юм.

“Монгол Улсын язгуур эрх ашиг, бүрэн эрхт байдал, ардчилсан үнэт зүйлсийг дээдлэн хамгаалж, хууль тогтоох эрх мэдлийг ард түмний ашиг сонирхолд үнэнчээр хэрэгжүүлнэ”



Улсын Их Хурлын 1-р тойрог буюу Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгаас сонгогдсон.





УИХ гишүүний тангараг өргөж байна

АРХАНГАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР ТОМИЛОГДСОН.

АРДЧИЛСАН НАМ
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, 6-р хороо
Залуучууд зочид буудлын байр 2 давхар 200 тоот
Утас: 77071206, 77711206
И-мэйл: election@democraticparty.mn
2024.08.26 № 02/247
танай _____-ны №_____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРООНД

Мэдээлэл хүргэх тухай

Ардчилсан Намын даргын 2024 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн дугаар Б/36 тушаалаар Улсын Их Хурлын гишүүн Пүрэвбаатарын Мөнхтулгыг Архангай аймгийн Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсныг үүгээр мэдэгдэж байна.

Хавсралт ... хуудас

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Н.ГАНИБАЛ

АРДЧИЛСАН НАМЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 23 өдөр Дугаар Б/36 Улаанбаатар хот

П.Мөнхтулгыг үүрэг гүйцэтгэгчээр
томилох тухай

Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5 дугаар бүлгийн 5.17.1[128] дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Пүрэвбаатар овогтой Мөнхтулгыг Архангай аймгийн Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгчээр 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн томилсугай.
2. Ардчилсан намын Үндсэн дүрэм, холбогдох журмын хүрээнд ажлын байрны чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Архангай аймгийн Ардчилсан намын даргын үүрэг гүйцэтгэгч / П.Мөнхтулга /-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажил хүлээлцүүлэхийг Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч (Н.Ганибал)-д даалгасугай.

ДАРГА Л.ГАНТӨМӨР



МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВТ СУУГДСАН
2026 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУД

АРХАНГАЙ АЙМАГ

ХАРХОРИН, ЦЭЦЭРЛЭГ - БАТЦЭНГЭЛ

Хархорин, Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Батцэнгэл чиглэлд баригдаж байгаа замын төгсгөлөөс хүүхдийн Тамир зуслан Батцэнгэл сумын төмөр бетон гүүр, мянганы замын хэвтээ тэнхлэгтэй холбох 62.04 км хатуу хучилттай авто замын эхлэл

30,000.0 сая 2026-2028

ТАРИАТ СУМ

Суман голын Хавтгай олмын төмөрбетон гүүр, 72 у/м /Архангай, Тариат сум/

2,814.0 сая 2026-2027

Тариат сумын Алтаад, Мөрөн, Бөөрөлжүүт багийн иргэд хөдөлмөрчид, малчдын эрүүл аюулгүй, чөлөөтэй зорчих нөхцлийг бүрдүүлэх үндсэн ач холбогдолтой "ХАВТГАЙ ОЛОМ"- ын төмөр бетон гүүрний төсөл 2026-2027 онд хэрэгжихээр Улсын төсөвт суулгасан.

- Төрийн үйлчилгээний цахим машин /киоск/ 2025 он

ЦЭЦЭРЛЭГ СУМ

Сум төвийн хатуу хучилттай авто зам, 2.1 км /Архангай, Цэцэрлэг сум/

3,647.3 сая 2026-2027


- Төрийн үйлчилгээний цахим машин /киоск/ 2025 он

БАТЦЭНГЭЛ СУМ

Таравчамбуулин хийдийн Авга дуганыг сэргээн засварлах

1,844.6 сая 2026-2027

- Төрийн үйлчилгээний цахим машин /киоск/ 2025 он



ӨГИЙНУУР СУМ

Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн хатуу хучилттай авто зам,28.5 км /Хангайн бүс/

43,603.2 сая

- Төрийн үйлчилгээний цахим машин /киоск/ 2025 он

ИХ ТАМИР СУМ

Ихтамир сумын гүүрнээс Тайхар чулуу хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.2 км /Архангай, Ихтамир сум/

5,853.3 сая 2026-2027

БАЯНХОНГОР-АРХАНГАЙ аймгийн **Чулуут сум** хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл | Хангайн бүс |

45,885.0 сая 2026-2028

Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж / Архангай /

1.0 тэрбум

ЭРДЭНЭБУЛГАН СУМ

Сургуулийн барилгын өргөтгөл / 5 дугаар сургууль /

6,555.3 сая 2026-2027

ЭРДЭНЭБУЛГАН СУМ

Цэцэрлэгийн барилга, 200 ор/Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар цэцэрлэг/

5,200.0 сая

- Төрийн үйлчилгээний цахим машин /киоск/ 2025 он

ӨЛЗИЙТ СУМ

Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Өлзийт сум/

11,000.0 сая

ЦЭНХЭР СУМ

Нийтийн ариун цэврийн байгууламж бүхий барилгын гадна замын авто зогсоол /Архангай, Цэнхэр сум/

1,608.5 сая

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2026 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

АРХАНГАЙ АЙМАГ

	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	2026 онд санхүүжих дүн /сая төгрөг/
1.	Цаг уурын харуулын барилга / Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд /	2026	2026	388.3
2.	Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт / Архангай, Эрдэнэбулган сум /	2026	2027	3,126.8
3.	Сургуулийн барилга, 320 суудал / Архангай, Өлзийт сум /	2026	2027	11,000.0
4.	Сургуулийн барилгын өргөтгөл / Архангай, Эрдэнэбулган сум, 5 дугаар сургууль /	2026	2027	6,555.3
5.	Цэцэрлэгийн барилга, 200 ор / Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар цэцэрлэг /	2026	2027	5,200.0
6.	Баянхонгор-Архангай аймгийн Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл / Хангайн бүс /	2026	2028	45,885.0
7.	Ихтамир сумын гүүрнээс Тайхар чулуу хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.2 км / Архангай, Ихтамир сум /	2026	2027	5,853.3
8.	Сум төвийн хатуу хучилттай авто зам, 2.1 км / Архангай, Цэцэрлэг сум /	2026	2027	3,647.3
9.	Хархорин, Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Батцэнгэл чиглэлд баригдаж байгаа замын төгсгөлөөс хүүхдийн Тамир зуслан-Батцэнгэл сумын төмөр бетон гүүр, мянганы замын хэвтээ тэнхлэгтэй холбох 62.04 км хатуу хучилттай авто замын эхлэл / Архангай /	2026	2028	30,000.0
10.	Суман голын Хавтгай олмын төмөрбетон гүүр, 72 у/м / Архангай, Тариат сум /	2026	2027	2,814.0
11.	Таравчамбуулин хийдийн Авга дуганыг сэргээн засварлах / Архангай, Батцэнгэл сум /	2026	2027	1,844.6
12.	"Заяын гэгээний хүрээ хийдийн цогцолбор"-ын засвар шинэчлэлт / Архангай, Эрдэнэбулган сум /	2026	2026	577.4
13.	Нийтийн ариун цэврийн байгууламж бүхий барилгын гадна замын авто зогсоол / Архангай, Цэнхэр сум /	2026	2026	1,608.5
14.	Шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц / Архангай, Эрдэнэбулган сум /	2026	2028	25,651.2
15.	Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө / Архангай, Өвөрхангай /	2026	2028	12,152.6
16.	Архангай аймаг дахь шүүхийн барилга / Архангай, Эрдэнэбулган сум /	2025	2026	8,043.3
17.	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж / Архангай /	2026	2026	1000.0

МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВТ СУУГДСАН
2026 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУД

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

Аймгийн төвд баригдаж байгаа **дулааны станцын 2 дугаар хэлхээ дэд бүтэц**

5,2 тэрбум 2026-2027

УЛААНБААТАР-АРВАЙХЭЭР чиглэлийн авто замаас **Хужирт сум** хүртэлх хатуу хучилттай авто зам, 43.3 км

38,5 тэрбум 2024-2026

ХУЖИРТ СУМ

Сумын төвийн хатуу хучилттай авто зам болон Хавцалын голын гүүр /Өвөрхангай, Хужирт сум/

8,012.8 сая

АРВАЙХЭЭР СУМ

Гэр хорооллын шугам сүлжээ

3.7 сая 2026-2027

ХАЙРХАНДУЛААН СУМ

Хөв цөөрөм / Өвөрхангай, Хайрхандулаан сум /

5,149.0 сая

БАРУУНБАЯН-УЛААН СУМ

Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/

3,192.0 сая

ГУЧИН-УС СУМ

Спорт заалны барилга, 250 суудал

1338.8 сая 2024-2026

ХАРХОРИН СУМ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/

14,609.5 сая

БАЯН-ӨНДӨР СУМ, 5-Р БАГ

Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал

2975 сая 2024-2026

БАЯНГОЛ СУМ


Номын сан, урлаг заал бүхий сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал

2,167.1 сая 2024-2027

БОГД СУМ

Босоо тэнхлэгийн авто замын Арвайхээр - Богд сумчиглэлийн 170 км хатуу хучилттай авто замын эхлэл /Өвөрхангай/

30,000.0 сая



МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2026 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	2026 онд санхүүжих дүн /сая төгрөг/
1.	Гал түймэр унтраах, аврах ангийн барилга / Өвөрхангай, Арвайхээр сум /	2026	2028	8,075.4
2.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга / Өвөрхангай, Хархорин сум /	2026	2028	14,609.5
3.	Хөв цөөрөм / Баянхонгор, Богд сум, Өвөрхангай, Хайрхандулаан сум, Өмнөговь, Баяндалай сум /	2026	2027	5,149.0
4.	Онги-Цагаан бургастай төсөл, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв / Өвөрхангай, Уянга, Зүүнбаян-Улаан сум, Өмнөговь, Мандал-Овоо сум, Улаан нуур /	2026	2028	44,490.0
5.	Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Доплерын Радарын станц / Өвөрхангай, Хархорин сум, Ховд, Буянт сум /	2026	2026	19,800.0
6.	Спорт заалны барилга, 250 суудал / Өвөрхангай, Хархорин сум, Номын хүрдэн сургууль /	2026	2027	3,192.0
7.	Босоо тэнхлэгийн авто замын Арвайхээр - Богд сум чиглэлийн 170 км хатуу хучилттай авто замын эхлэл / Өвөрхангай /	2026	2028	30,000.0
8.	Сумын төвийн хатуу хучилттай авто зам болон Хавцалын голын гүүр / Өвөрхангай, Хужирт сум /	2026	2027	8,012.8
9.	Шанхын хийдийг сэргээн засварлах зураг төсөв / Өвөрхангай, Хархорин сум /	2026	2026	500.0
10.	Спорт заалны барилга, 250 суудал / Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум /	2026	2027	3,192.0
11.	Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө / Архангай, Өвөрхангай /	2026	2028	12,152.6
12.	Мал бэлтгэх тогтолцоо бүхий мах боловсруулах, экспортлох цогцолбор жишиг үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв / Өвөрхангай, Хархорин сум /	2026	2026	500.0
13.	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц / Өвөрхангай /	2025	2027	18,740.1

МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВТ СУУГДСАН
2026 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУД


БАЯНХОНГОР
АЙМАГ

Арвайхээр-Баянхонгор чиглэлийн авто замаас **Уянга сум** хүртэлх 50 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хангай бүс/
30,000.0 сая

ӨЛЗИЙТ СУМ
Бумбатын амны услалтын системийн засвар, шинэчлэлт /Баянхонгор, Өлзийт сум/
2,998.9 сая

БАЯНХОНГОР, ӨЛЗИЙТ, ЭРДЭНЭЦОГТ СУМ
Баянхонгор Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км
42,9 тэрбум 2024-2026

АЙМГИЙН ТӨВ (БАЯНХОНГОР СУМ)
Дулааны станц төслийн 2 дугаар хэлхээ, дэд бүтэц
11,8 тэрбум 2025-2027



Сургуулийн барилга, 640 суудал "Соого сейкео" сургууль
5181.3 сая 2024-2026

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны барилга, 150 ор
2217.7 сая 2024-2026

Наркологийн төв эмнэлгийн тбарилга
5010.1 сая 2024-2026

Наркологийн төв эмнэлгийн тбарилга
5010.1 сая 2024-2026

Гал түймэр унтраах, аврах ангийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/
8,075.4

ЖИНСТ СУМ
Сумын төвийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Жинст сум/
3,441.4 сая

БОГД СУМ
Түйн голын төмөр бетон гүүр, 64.75 у/м /Баянхонгор, Богд сум/
3,250.0 сая

БОГД СУМ
Хөв цөөрөм /Баянхонгор, Богд сум/
5,149.0 сая

ШИНЭЖИНСТ СУМ
Баянхонгор-Говь-Алтай чиглэлийн авто замаас Шинэжинст сум хүртэлх 204 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хангайн бүс/
30,323.3 сая

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2026 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	2026 онд санхүүжих дүн /сая төгрөг/
1. Гал түймэр унтраах, аврах ангийн барилга / Баянхонгор, Баянхонгор сум /	2026	2028	8,075.4
2. Хөв цөөрөм / Баянхонгор, Богд сум, Өвөрхангай, Хайрхандулаан сум, Өмнөговь, Баяндалай сум /	2026	2027	5,149.0
3. Цаг уурын харуулын барилга / Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд /	2026	2026	388.3
4. Арвайхээр-Баянхонгор чиглэлийн авто замаас Уянга сум хүртэлх 50 км хатуу хучилттай авто замын эхлэл / Хангай бүс /	2026	2028	30,000.0
5. Баянхонгор-Архангай аймгийн Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл / Хангайн бүс /	2026	2028	45,885.0
6. Баянхонгор-Говь-Алтай чиглэлийн авто замаас Шинэжинст сум хүртэлх 204 км хатуу хучилттай авто замын эхлэл / Хангайн бүс /	2026	2028	30,323.3
7. Сумын төвийн инженерийн шугам сүлжээ / Баянхонгор, Жинст сум /	2026	2027	3,441.4
8. Бумбатын амны услалтын системийн засвар, шинэчлэлт / Баянхонгор, Өлзийт сум /	2026	2027	2,998.9
9. Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн 2 дугаар хэлхээ, дэд бүтэц / Баянхонгор, Баянхонгор сум /	2025	2027	51,948.9

ТАРАВЧАМБУУЛИН ХИЙДИЙН АВГА ДУГАНЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ / АРХАНГАЙ, БАТЦЭНГЭЛ СУМ /

₮ 1,844.63 САЯ







СУМАН ГОЛЫН ХАВТГАЙ ОЛМЫН ТӨМӨРБЕТОН ГҮҮР, 72 У / М / АРХАНГАЙ, ТАРИАТ СУМ /

₮ 2,814.03 САЯ







АРХАНГАЙ АЙМГИЙН ИХТАМИР СУМЫН ТӨВ ЗАМЫН ГҮҮРНЭЭС ТАЙХАР ЧУЛУУ ХҮРТЭЛХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ ЗАСМАЛ ЗАМ ТӨСӨВТ СУУСАН


₮ 5,853.33 САЯ



Ихтамир сумын гүүрнээс Тайхар чулуу хүртэлх 3.2 км хатуу хучилттай авто зам | Архангай, Ихтамир сум |

Хархорин, Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Батцэнгэл чиглэлд баригдаж байгаа замын төгсгөлөөс хүүхдийн Тамир зуслан-Батцэнгэл сумын төмөр бетон гүүр, мянганы замын хэвтээ тэнхлэгтэй холбох 62.04 км хатуу хучилттай авто замын эхлэл / Архангай /

₮ 30,000.0 САЯ



МЯНГАНЫ ЗАМААС ӨГИЙНУУР СУМ ХҮРТЭЛХ 28.5КМ АВТО ЗАМЫН АЖИЛ


₮43,603.2 САЯ


Мянганы замаас Өгийнуур сум хүртэлх 28.5км автозамын ажлыг 2025 оны улсын төсөвт суулгасан билээ. Ажил гүйцэтгэх, хяналт тавих компаниуд шалгарч автозамын барилгын ажил эхэлж авто замын барилгын ажил эрчимтэй явж байна.





Татвар төлөгчдийн мөнгөөр үр ашигтай, олон жилийн насжилттай, чанартай авто зам барих ёстойг сануулж далангийн материал, дайргын ордыг үзэж танилцлаа. Хяналт тавих, зам барих залуучуудад эх оронч сэтгэлээр хандаж, компани ашгийн төлөө ажилладаг ч стандартыг чанд мөрдөх нь тэргүүн эрэмбэ юм гэдгээр ажлын амжилт ерөөлөө.







Уг замын эдийн засгийн үр өгөөж өндөр бөгөөд цаашид Хотонт сумтай холбогдож Архангай, Завхан, Увс чиглэлийн авто зам болон Мянганы замын холбоос болох юм.

АЛТАН ШАР ЗАМ ӨЛЗИЙТЭЙ БАЙГ

СУРГУУЛИЙН БАРИЛГЫН ӨРГӨТГӨЛ
/ АРХАНГАЙ, ЭРДЭНЭБУЛГАН СУМ, 5 ДУГААР СУРГУУЛЬ /

₮ 6,555.30 САЯ



СУРГУУЛИЙН БАРИЛГА, 320 СУУДАЛ
/ АРХАНГАЙ, ӨЛЗИЙТ СУМ /

₮ 11,000.00 САЯ



2025.07.09
БАТЛУУЛСАН ХУУЛИЙН ТӨСӨЛ

Хаврын ээлжит чуулганаар ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлуулав.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 сарын 09 өдөр — Төрийн ордон, Улаанбаатар хот

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Жолоочийн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг:
"13.7.Даатгуулагч энэ хуулийн 16.6-д заасан тохиолдолд энэ хуулийн 13.1.2-т заасан цагдаагийн байгууллагад мэдэгдэх үүргээс чөлөөлөгдөнө."

2/16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг:
"16.7.Энэ хуулийн 16.6-д заасан тохиолдолд даатгагч энэ хуулийн 15.2-т заасан үүргээс чөлөөлөгдөх ба хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа үнэлгээний тайлан шаардахгүйгээр эд хөрөнгийг засуулахаар тохиролцож болно."

2 дугаар зүйл.Жолоочийн даатгалын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг:
"13.3.Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээд нь даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягтыг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр даатгалын тохиолдол гарсан даруйд бөглөнө."

2/16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг:
"16.6.Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй, холбогдогч талуудын тээврийн хэрэгслээс бусад эд хөрөнгийн хохиролгүй, холбогдогч талууд өөр хоорондоо маргаангүй тохиолдолд даатгагч, жолоочийн даатгалын сан нь даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл, баримтыг цахимаар даатгуулагч болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.6-д заасан автоматжуулсан системээс хүлээн авч, нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ."

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН



2025 оны 4 сараас өмнө жолоочийн албан журмын даатгалын нөхөн төлбөр авахад цагдаагийн тодорхойлолт шаардлагагүй болгох хуулийн төслийг өргөн барих талаар хэвлэлийн мэдэгдэл хийж байсан билээ. 2025.07.09 өдөр хуулийн нэмэлт өөрчлөлт УИХ-аар 70%- иар батлагдлаа.

Жолооч нар маргаангүй тохиолдолд цахим хэлбэрээр баталгаажуулж бусдад саад түгжрэл учруулалгүйгээр даатгалаас нөхөн төлбөрөө чирэгдэлгүй авах эрх зүйн орчин нээгдлээ.

Заавал цагдаа хүлээж гудамжаараа түгжирч, зөрчлийн хуулиар 100к торгуулдаг байсан асуудал ард хоцорлоо.

1 / 1

ЗӨРЧЛИЙН ХУУЛИАР 100К ТОРГУУЛАХ, ЦАГДААГИЙН ТОДОРХОЙЛОЛТ ШААРДЛАГАГҮЙ БОЛЛОО.

САНААЧИЛСАН ХУУЛИЙН ТӨСӨЛ

ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙГООР “БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ” -ИЙН 10 ДУГААР ЗҮЙЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ САНААЧЛАВ

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн зааснаар манай улс иргэдийн нийгмийн баталгааг хангах үүргийг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан.

Монгол Улсад ахмад настнууд хүн амын томоохон хэсгийг эзэлдэг бөгөөд тэдний орлого нь зөвхөн тэтгэвэрт тулгуурладаг. Ахмад настнуудын хувьд хэрэглээний зээл авах гол эх үүсвэр нь **тэтгэврийн зээл** байдаг. Гэвч зах зээлийн нөхцөлөөс шалтгаалан энэ зээлийн хүү өндөр (16–21%) тогтож, ахмадууд өрийн дарамтад орох болсон. 280 мянга орчим ахмад тэтгэврийн зээлтэй, 2.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд энэ нь нийт хэрэглээний зээлийн 15 орчим хувийг эзэлж байна.

Манай улсад ахмад настнуудын тэтгэврийн зээлийн хүү харьцангуй өндөр байгаа нь тэдний санхүүгийн дарамтыг нэмэгдүүлж байна. Тэтгэврийн зээл нь төлөгдөх эх үүсвэр тодорхой эрсдэлгүй зээл тул арилжааны банкуудаар олгогдож буй Тэтгэврийн зээлийн хүүгийн дээд хязгаарыг бодлогоор барьж ахмад настнуудын зээлийн дарамтыг багасгах зорилгоор хуулийн төслийг санаачлан ажиллаж байна.









ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙГООР “БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН 10 ДУГААР ЗҮЙЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн зааснаар манай улс иргэдийн нийгмийн баталгааг хангах үүргийг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан.

Тэтгэврийн зээлийн гол зорилго нь өндөр настай иргэдийн нийгмийн баталгааг хангахад чиглэсэн байдаг билээ. Энэхүү зорилгыг баталгаажуулж хууль тогтоогчийн зүгээс “Ахмад настны тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцийн өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ” гэж хуульчилж өгсөн. Цаашлаад ахмад настны нийгмийн баталгааг хангахад дан ганц орлогыг нэмэгдүүлэхээс гадна зээлийн хүүг багасгах шаардлагатай. Гэвч дээр дурдсанчлан зээлийн хүүг банк өөрөө тогтооно гэж хуульчилж өгсөн байх тул ахмад настны тэтгэврийн зээлийн хүүг багасгахын тулд банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна гэж үзлээ.



ЖАГСАЖ БУЙ АХМАДУУДЫН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗАЖ САНАЛ БОДЛЫГ НЬ СОНСОВ.









2025.04.26
УИХ-ЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН 210 ДУГААР АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААН

18 жилийн дараа Эрдэнэс таван толгой, Оюу толгой, Асгат, Цагаан суварга, Тавантолгойн асуудлаар УИХ албан ёсоор санал дүгнэлт гаргахаар боллоо.

2007 онд УИХ тогтоол гаргаж Тавантолгойн орд газрын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, түүнийг хэрхэн эзэмших талаархи саналыг өргөн мэдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосноос хойш өнөөг хүртэл энэхүү асуудлаар УИХ-ын түвшинд хэлэлцүүлэг өрнөж байгаагүй юм.

2025.02.17-нд Засгийн газраас ажлын хэсэг байгуулж, Тавантолгойн орд газрыг (Ухаа худаг) гэрээ байгуулан лиценз хэлбэрээр олгосон нь хууль зөрсөн байна гэсэн дүгнэлт гаргасны үндсэн дээр Засгийн газар тогтоолын төсөл санаачилж УИХ-д хүргүүлээд 54 хоног өнгөрсний дараа УИХ-ын даргын захирамж гарч, 11 гишүүний бүрэлдэхүүнтэй санал дүгнэлт гаргах ажлын хэсэг байгууллаа.

Ийнхүү 18 жилийн дараа "Тавантолгой", "Ухаахудаг"-н асуудал УИХ-ын түвшинд очиж, санал дүгнэлт гаргах болсонд ажлын хэсгийн ахлагчийн хувьд баяртай байна. Үндсэн хуульд зааснаар баялагтаа эзэн болох ард түмний эрх ашиг хангагдахад нэг алхам ойртлоо.





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 08 өдөр Дугаар 210 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.11 дэх заалт, 13.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

П.Мөнхтулга -Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд:

Х.Баасанжаргал -Монгол Улсын Их Хурлын гишүүн
Р.Батболд -Монгол Улсын Их Хурлын гишүүн
О.Батнайрамдал -Монгол Улсын Их Хурлын гишүүн
Б.Бат-Эрдэнэ -Монгол Улсын Их Хурлын гишүүн
Э.Болормаа -Монгол Улсын Их Хурлын гишүүн
Ш.Бямбасүрэн -Монгол Улсын Их Хурлын гишүүн
С.Зулпхар -Монгол Улсын Их Хурлын гишүүн
Б.Жаргалан -Монгол Улсын Их Хурлын гишүүн
М.Нарантуяа-Нара -Монгол Улсын Их Хурлын гишүүн
Д.Пүрэвдаваа -Монгол Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах, мэдээлэл, судалгаа гаргуулан дүн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (П.Мөнхтулга)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох санал, дүгнэлтээ гарган, цаашид авах арга хэмжээний санал, шийдвэрийн төсөл боловсруулж, Улсын Их Хурлын 2025 оны намрын эцэжит чуулганы хугацаанд танилцуулахыг ажлын хэсэг (П.Мөнхтулга)-т даалгасугай.

ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН

2025000638

АЖЛЫН ХЭСГИЙН АЖЛУУДААС

Аж Үйлдвэржилтийн Байнгын Хорооны гишүүний хувиар Эрдэнэс Таван Толгой ХХК, Таван Толгой Төмөр Зам ХХК, Цагаан Хад, Гашуун сухайт, Ганц Модны боомт хил холболтын асуудлаар газар дээр нь ажилласан.

- Нүүрс баяжуулах үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй байна,
- Таван толгой төмөр замын нэвтрүүлэлт суурилагдсан хүчин чадлынхаа 20 хувьд дөнгөж ажиллаж байна.
- Энэ байдлаараа хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа хойшлогдож байна.
- Ганц модны агуулах дүүрсэн шалтгаанаар Монгол талын нүүрсний тээвэр удааширч дараалал үүссэн.
- Гашуун сухайтын боомтоор нэвтрэх 10 салаа замтай ч түүнийгээ бүрэн ашигладаггүйгээс дараалал ихэсдэг.
- Хил холболтын төмөр зам 8км газраар зөрснөөс бүтээн байгуулалтын ажил 22 сар буюу түүнээс дээш хугацаагаар уртсах төлөвтэй байна.
- Нүүрсний үнэ өмнөх оны мөн үеэс 44 хувь буурсан
- Цагаан хадны орчин нөхцөл эрт үеийнхээс өөрчлөгдөөгүй ажиллах нөхцөл хүнд хэвээр байна.
- Цогцэций чиглэлийн нислэгтэй болох талаар ажилчид олноороо хүсэлт тавьж байна.

Дээрх байдлаас дүгнээд:

- Ирэх хаврын чуулганаар хэлэлцүүлэх хил холболтын гэрээг сайтар нягталж, гадаад харилцааны түвшинд Баяннуур аймагтай тусгайлан хэлэлцээр хийх. Үүнд Ганц модны боомтын агуулахыг өргөжүүлэх, авто тээврийн нэвтрүүлэлтийг сайжруулах талаар 2 орны хамтарсан ажлын хэсэг гарч харилцан ашигтай шийдлүүдийг зөвшилцөх.
- Биржээр борлуулагдаж байгаа нүүрсний Инкотерм нөхцөлийг DAP-Gantsmod байгааг FOB-Gashuun Sukhait нөхцөлөөр борлуулах нэмэлт сонголтыг судлах
- Аж үйлдвэржилтийн байнгын хороо Гашуун сухайтын боомтоор бүтээгдэхүүн экспортлогч нарын сонсгол, хэлэлцүүлэг хийх. Хамтын шийдлүүдийг ЗГ-т чиглэл болгох.
- Цогцэций чиглэлийн нисэх онгоцны эх үүсвэрийг судлах, ростергүй чөлөөт цагаар дунд зайны бусад аймгууд руу нислэг хийж хөрөнгө оруулалтыг нөхөх талаар судлахаар боллоо.







АЖЛЫН ХЭСГИЙН АЖЛУУДААС

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны Газрын тос боловсруулах үйлдвэрийн үйл явцад хяналт шалгалт хийх ажлын хэсэг Дорноговь аймагт ажиллаа.

2015 онд хоёр улсын хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээлийн гэрээгээр Монгол улсад Газрын тос боловсруулах үйлдвэрийг 1.6 тэрбум доллараар барьж хүлээлгэж өгөх юм. Бид жилийн 1.7% хүүтэйгээр Энэтхэг улсад эргүүлж төлөх ЗЭЭЛ!
Гэтэл газар дээр 800 гаруй ажилчид ажиллаж байгаагаас 700 гаруй нь Энэтхэг 100 нь Монгол гэсэн харьцаатай байна. Цаашид ажилчдын тоо 2800 хүрэх төлөвлөгөөтэй байгаа гэж танилцууллаа.

ИЙМД.
Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд Монгол ажилчдыг сургаж ажиллуулах, Монгол компаниудыг туслан гүйцэтгэгчээр оролцуулах талаар төслийг гүйцэтгэгч Энэтхэг улсын МЕГХА Инжинеринг ХХК-ны Монголын төслийг хариуцсан захирал Муралитай санал солилцож ойрын хугацаанд талуудыг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг хийхээр тохирлоо.







МОНГОЛ-ИСЛАНД ХОЁР УЛСЫН ПАРЛАМЕНТЫН БҮЛГИЙН ДАРГААР СОНГОГДОВ.

Монгол-Исланд хоёр улсын парламентийн бүлгийн даргын хувиар Исланд улсад 2025 оны 8-р сард УИХ-н гишүүдийн хамтаар айлчлал хийсэн. Уг айлчлалын хүрээнд газрын гүний дулаанаар дэлхийд тэргүүлэгч Исланд улсын сангийн сайд Daði Már Kristófersson-той уулзаж судалгааны тэргүүлэх Arctic Green Energy корпорациар Архангай Баянхонгор аймгуудад газрын гүний дулаанаар иргэдийг хангах боломжийг судлах ажлыг эхлүүлэн 2026 онд орон нутагт судалгааны ажлыг хийхээр тохиролцов.





ХАНГАЙН БҮСИЙН АНХДУГААР ЧУУЛГАН

Хангайн бүс, Архангай аймагт Засгийн Газар хуралдаж байна. Бүсийн иргэдэд тулгамдсан асуудлыг эрэмбэлэн 2024-2028 оны хамтарсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулсан. Энэ хуралдаанаар Хангайн бүсэд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, тулгамдсан асуудлуудыг ЗГ-ын түвшинд эцэслэн тогтож ЗГ-ын хуралдааны тогтоол гаргахад өөрийн саналыг тусгуулахаар Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хүргүүлж ажиллсан.





ТАЙХАР ЧУЛУУГАА АВРАХ СУДАЛГААНЫ АЖЛАА ЭХЛҮҮЛЭВ.

Архангай аймгийн бэлгэ тэмдэг Тайхар чулуу нь 2000 жилийн өмнөхөөс дундад зуун хүртэл цаг хугацаанд хамаарах сүг зураг, овог аймгийн тамга тэмдэг, янз бүрийн хэлний бичээс зэрэг утга соёлын үнэт зүйлсийг нүүдэлчдийн архив мэт хадгалан иржээ. Тайхар чулууны бичээснүүд XIX зууны сүүл үеэс эрдэмтэд, судлаачдын анхааралд өртөх болсон бөгөөд зураг дүрсийн хамгийн эртнийх нь чулуун зэвсгийн сүүл үед холбогдох улаан зосоор зурсан тамга тэмдэг, амьтны дүрс бөгөөд Түрэг, Уйгар, Монгол, Түвд, Манж, Хятад зэрэг эрт эдүгээгийн олон улс үндэстний хэлээр бичсэн YII- XYII зууны үеийн 150 гаруй бичээс байдаг боловч он жил өнгөрөх тусам улам бүдгэрч, хорлон сүйтгэгч нарын гарт баларч байна. Хамгийн эртнийх нь VI-VIII зууны Түрэгийн хаант улсын үеийн "Орхон Енисейн бичиг" хэмээн алдаршсан руни бичиг юм. Харин хамгийн олон тоотой нь уйгуржин бичиг бөгөөд 70 орчим хадгалагдан үлдсэний хамгийн эрт үеийнх нь XIV зууны үетэй холбогддог. Эдгээр бичээсийн дотор тод үсгээр бичигдсэн үлэмж тооны маань, тарнийг оруулаагүй болно.

Бичээснийн 70 орчим нь монгол үсгээр бичсэн байдаг ба XY-XYII зууны үеийн Монголын төрийн зүтгэлтэн Ойрадын Хуухай Даюу, Халхын Цогт хунтайжийн нэрс уншигддаг байсан байна. Мөн 1722 онд Дайчин улсын Энх-Амгалангийн ямар нэгэн бичиг зарлигийг Равдангаар хүргүүлсэн тухай бичээс бий. Халхын Нонохуй Үйзэн ноёны харьяат Аварга хошуучийн бичээсийг сийрүүлбэл, "Ум ма ни бад ме хум ору Үйзэн ноёны аварга хошууч бичив" гэсэн хоёр мөр бичиг юм. Энд нэр дурдагдаж буй Үйзэн ноён хэмээх Ноноху 1535 онд төрсөн, Батмөнх Даян хааны хөвүүн Халхын Гэрсэнз жалайр хунтайж (1513-1548)-ийн гуравдугаар хөвүүн, Халхын Түшээт хан Абтайн эцэг нь болно.

Иймд хувийн зардлаараа эрдэмтдийг 2025 оны 8 сард судалгааны ажил хийлгэж орчин цагийн химийн будгаар будсан хорлон сүйтгэгч нарын ул мөрийг арилгаж 2000 жилийн тэртээхээс дундад зуун хүртэлх 150 гаруй эртний түүхэн бичээсийг дахин сэргээх ажлын судалгааг эхлүүлэв.











НЭГДСЭН ЧУУЛГАН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРЛУУДАД ХЭЛСЭН ҮГНЭЭС



УИХ-ын гишүүн П.Мөнхтулга:
-Төрийн өмчит компаниудаа цэгцлэх цаг болсон. Хувь эзэмшигч, ногдол ашиг хүртэгч нь төр, монголын ард түмэн юм чинь төрийн өмчит компанийн орлого улсын төсөвт ирэх ёстой. Гэтэл худал тайлан гаргаж, ашгаа нуугаад эсвэл олсон ашгаараа 100 сая төгрөгөөр өөрсдийгөө шагнаач юм.



П.Мөнхтулга: Тэтгэврийн зээлийг хэтэрхий өндөр хүүтэй байна гэж үзсэн. Тэтгэврийн зээл бол хамгийн эрсдэлгүй зүйл.

П.Мөнхтулга: Тэтгэврийн зээл бол хамгийн эрсдэлгүй, баталгаатай зээл. Ахмадууд 600 мянган төгрөг амьдралд нь хүрэлцэхгүй болохоор зээл авч байгаа. Гэтэл эрсдэлт зээлтэй ижил өндөр хүүтэй байж болохгүй.

П.Мөнхтулга: Малын түүхий эдийн үнэ муу, иргэдийн амьдрал хүнд байгаа хөдөөд залуучуудыг үлдээж байгаа ганц зүйл бол морин уралдаан. Малчдын морь уралдах боломжгүй "боломжтой" хэсгийн наадам болоод хувирчихсан энэ үед 10 жилийн хугацаанд импортыг зогсоох нь зөв.



П.Мөнхтулга: Түүхий эд үнэд хүрэхгүй байгаа учраас малчид хот руу шилжиж байна. Тиймээс та Ерөнхий сайдаар томилогдвол орон нутагт эдийн засгийн эргэлтийг бий болгоход анхааралаарай.

П.Мөнхтулга: ХАА-н бодлого, малчдын амьжиргааг хэрхэн дэмжих вэ?

П.Мөнхтулга: 2028 он хүртэл бид арьс шир боловсруулах үйлдвэртэй болохгүй нь. Хэзээ арьс ширийг үйлдвэрлэж эцсийн бүтээгдэхүүн болгодог болох юм. Засгийн газар хамтарч байгаа үедээ энэ салбартаа зоригтой реформ хиймээр байна.



П.Мөнхтулга: Авлига өгсөн хүн өөрөө хүлээн зөвшөөрч, нотлох баримтаа гаргаж тавих юм бол ялаас чөлөөлдөг зохицуулалт олон улсад байдаг. Манай улсад өгсөн авсан хоёулаа ял авдаг учир нуугаад илрүүлэлт удааширдаг. Үүнтэй холбоотой холбогдох хуулиудыг судалж өөрчлөлт оруулах тал дээр анхаарч ажиллахыг хүсье.

П.Мөнхтулга: Малчдын малын арьс шир хог дээр хаягдаж байна. Кино үзэхэд төсөвлөгдөж байгаа 18 тэрбум төгрөгийг Дарханы арьс ширний цогцолборт хөрөнгө оруулж болохгүй юу?

П.Мөнхтулга: Малын түүхий эдийн үнэ муу, иргэдийн амьдрал хүнд байгаа хөдөөд залуучуудыг үлдээж байгаа ганц зүйл бол морин уралдаан. Малчдын морь уралдах боломжгүй "боломжтой" хэсгийн наадам болоод хувирчихсан энэ үед 10 жилийн хугацаанд импортыг зогсоох нь зөв.

П.Мөнхтулга: ХБИ-ийн асаргааны тэтгэмж 302,500 төгрөг байхад эрхтэн бүтэн, эрүүл саруул байгаа бол УИХ-ын гишүүд тэтгэмж авахаа болих хэрэгтэй.

П.Мөнхтулга: Манай Монгол улс ичмээр юм аа. Онгоцны буудал дээр буусан иргэдийнхээ чемоданыг ухаад зогсчих юм. Тэгсэн хэрнээ гаалиар гарч байгаа шаланзыг харахгүй юм.

П.Мөнхтулга: Иргэдийн хувьд нөхөн төлбөрөө авахын тулд заавал цагдаагийн тодорхойлолт, даатгалын шуурхай албыг иртэл хүлээдэг. Энэ хооронд нь бусад бүх машинууд цагдаа ирэхийг хүлээж зогсдог байсан. Хоёр машин мөргөлдсөний төлөө бүтэн гудамжаараа хүлээдэг байсан асуудал ард хоцорсон.

П.Мөнхтулга: Тэтгэвэр барьцаалсан зээл бол хамгийн эрсдэлгүй зээл учраас хамгийн бага хүүтэй байх ёстой. Гэтэл манайд хэрэглээний зээлтэй адилхан, өндөр хүү авдаг. Тиймээс ахмадууд болон Монголбанкныхантай зөвшилцөж, хамгийн зохистой хувилбарт оруулъя гэж байгаа юм.

П.Мөнхтулга: Малын гаралтай түүхий эд өнөөдөр жалганд хаягдаж байна. Энэ Засгийн газар хөдөө аж ахуйн салбартаа хэрхэн анхаарч, эдийн засгаа солонгоруулах вэ?

П.Мөнхтулга: Эдийн засгаа солонгоруулна гэж ярьдаг. Өнөөдрийн байдлаар уул уурхайгаас хамаарсан хэвээрээ. Малчдын орлогыг нэмэгдүүлнэ гэж ярьдаг.

П.Мөнхтулга: Онтрэ ХХК хайгуулын зардал огт гаргаагүй байх нь. Хуулиараа компани эрсдэлээ үүрээд хөрөнгө оруулалтаа хийж хайгуулаа хийх ёстой байдаг.

П.Мөнхтулга: Оюутолгойд лиценз эзэмшиж байгаа "Онтрэ" ХХК хайгуулын зардал огт гаргаагүй тул Монголын Засгийн газар 34 биш 100 хувь эзэмших боломжтой. Монголын баялгийг хоёр компани хоорондоо тохироод, цээжинд багтсан тоогоороо хувааж идэж болохгүй.









ТӨРИЙН ДЭЭД ОДОН ГАРДУУЛСАН ТУХАЙ

Нутгийн иргэдийн хөдөлмөр зүтгэл, салбар салбарт оруулсан үнэтэй хувь нэмрийг төрөөс үнэлэн Төрийн одонгоор шагнаж урамшууллаа. Төрийн шагнал нь иргэн бүрийн хөдөлмөрийг зөв үнэлж, нийгэмд үлэмж хувь нэмэр оруулсан бүтээлч санаачилга, хичээл зүтгэлийн батламж болдог билээ.

Төрийн дээд одон гардуулах энэхүү арга хэмжээ нь орон нутгийн иргэдийн идэвх, оролцоог дэмжиж, сайн үйлс, үр бүтээлтэй хөдөлмөрийг алдаршуулах Чухал уламжлалын нэг юм. УИХ-н гишүүний хувиар Төрийн дээд одон 210, Аварга малчин, Аварга саальчин, салбарын шагналаар 100 гаран иргэдийг шагнаж урамшуулжээ.






БАГШ
АРХАНГАЙ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР


















ЖИРУХ БИЧИГ

АРХАНГАЙН БАХАРХАЛ — БАЯНМӨНХИЙН ЭРМҮҮНЗАЯА

Архангай аймгийн тамирчин Баянмөнхийн Эрмүүнзаяа дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 7 алт, 1 мөнгөн медаль хүртэж, Монголын даамын спортын нэр хүндийг дэлхийд бататгалаа. Тэрээр Олон улсын их мастер Д.Баттулгын удирдлагатай "Даам Месси" клубт бэлтгэл хийдэг бөгөөд Монголын хамгийн ирээдүйтэй залуу тамирчдын нэгээр тодорч байна.Энэхүү амжилтыг нь дэмжих хүрээнд би шаардлагатай санхүүгийн болон бусад дэмжлэгийг үзүүлэн ажиллаж, олон улсын тэмцээнд оролцох нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулаа.

2022 Анталья (Турк) рапид төрөл - мөнгө G-8 охид
2022 Анталья (Турк) блиц төрөл - алт G-8 охид
2023 Полице (Польш) үндсэн төрөл - алт G-8 охид
2023 Полице (Польш) рапид төрөл - алт G-8 охид
2023 Полице (Польш) блиц төрөл - алт G-8 охид
2025 Анталья (Турк) үндсэн төрөл - алт G-10 охид
2025 Анталья (Турк) рапид төрөл - алт G-10 охид
2025 Анталья (Турк) блиц төрөл - алт G-10 охид







АРХАНГАЙД ДЭЛХИЙН ТАМИРЧИД БЭЛТГЭГДЭНЭ

Америкийн нэгдсэн улсын иргэн хөлбөмбөгийн дасгалжуулагч Marc Cuierco хамтран Архангай аймгийн өсвөрийн хөл бөмбөгийн шилдэг тамирчдыг бэлтгэх үйлсэд хамтран ажиллахаа илэрхийллээ.











ТОЙРГИЙН ИРГЭДТЭЙ УУЛЗСАН УУЛЗАЛТУУД

Тойргийн иргэдээ Төрийн ордонд хүлээн авч, тулгамдсан асуудал, санал хүсэлт, хөгжлийн бодлого, шийдлийн талаар өргөн хүрээтэй уулзалтуудыг зохион байгууллаа. Уулзалтаар орон нутгийн хөгжил, дэд бүтэц, төрийн үйлчилгээг сайжруулахтай холбоотой иргэдийн байр суурийг сонсож, салбар бүрийн бодлогын хэрэгжилттэй уялдуулан шийдэл тодорхойлохыг зорив.

Төрийн ордонд иргэн бүрийн дуу хоолой хүрч, асуудал бүрийг бодит мэдээлэл, баримтад тулгуурлан хэлэлцсэн нь уулзалтыг үр дүнтэй болголоо.

Иргэдийн санал хүсэлтийг цаашдын хууль тогтоох ажлын төлөвлөгөө, бодлогын шийдвэрт тусган ажиллахаа илэрхийлж, ТӨР-ИРГЭНИЙ хамтын ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхээ тэмдэглэв.

Энэхүү уулзалт нь тойргийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шийдэлд хүрэх бодит механизмыг бүрдүүлэх, төрийн нээлттэй, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх чухал алхам болж байна. Тойргийн 1000 орчим иргэд гишүүний урилгаар төрийн ордонтой танилцаж “Есөн хөлт цагаан туг”-д хүндэтгэл үзүүлэн дурсгалыг зураг татуулж, чуулганы үйл ажиллагаатай танилцсан байна.







Архангай аймгийн 4-р цэцэрлэгийн төлөөлөл







АРХАНГАЙ АЙМГИЙН ӨРХИЙН ЭМЧ НАРЫН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА.



Архангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчидийн Хурлын төлөөлөгч Ж.Ариунаагийн санаачилгаар Өрхийн эмч нарын төлөөлөл Төрийн ордонд намын дарга Улсын Их Хурлын Гишүүн П.Мөнхтулгатай уулзаж тулгамдаж буй асуудлын талаар санал солилцлоо.





АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗДТГ-Н ТӨЛӨӨЛӨЛ









ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ЗДТГ-Н ТӨЛӨӨЛӨЛ









АРХАНГАЙ АЙМГИЙН БАГШ НАРЫН ТӨЛӨӨЛӨЛ









АРХАНГАЙ АЙМАГ ӨГИЙНУУР СУМЫН ТӨЛӨӨЛӨЛ















МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

ПҮРЭВБААТАРЫН МӨНХТУЛГА



Пүрэвбаатарын **Мөнхтулга**

munkhtulga@parliament.mn